



Г

“НЭР БҮХИЙ 310” ХХК-Д

Г

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2024.04.04 № ЦАТ-11/04/10

танай \_\_\_-ны № \_\_\_-г

Г

### Хамтран ажиллах тухай

Г

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 2.1.6-д “брокер, агент нь Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх”, 6.5-д “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн агент өөрчлөгдөх, шинээр томилогдсон тухай мэдээллийг албан бичгээр улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлж, бүртгүүлнэ” гэж тус тус заасан нөхцөл, шаардлагыг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь биелүүлэх үүрэгтэй.

Гэвч Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлгүй брокер, агент нь тусгай зөвшөөрөл авсан гэж иргэдийг төөрөгдүүлэх, хууран мэхлэх, залилах, мөн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдэд ажиллах тохиолдлууд цөөнгүй илэрсэн.

Иймд тус Хорооны бүртгэлд бүртгүүлээгүй агентуудад Зөрчлийн тухай хуулийн 3.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хуульд заасны дагуу зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчил илэрсэн өдрөөс үйл ажиллагааг зогсооно”, мөн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “..., хуульд заасны дагуу зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй явуулах санхүүгийн бусад үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр, эсхүл хууль бусаар явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заасны дагуу хуульд заасан холбогдох арга хэмжээг авахыг үүгээр мэдэгдье.

Танай компанид өнөөдрийн байдлаар ажиллаж байгаа нийт брокер, агентынхаа мэдээллийг хавсралтын дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд албан бичгээр ирүүлж, хамтран ажиллана уу.

Хавсралт: 1 хуудастай.



Санхүүгийн зохицуулах хорооны  
2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн  
ЦАТ-11/04/10 тоот цахим албан бичгийн хавсралт

“.....” ХХК-ийн брокер, агентын мэдээлэл

№	Овог	Нэр	Бүртгэлийн дугаар	Утасны дугаар	Цахим шуудан	Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан сургалтын гэрчилгээ авсан эсэх			Мэдээллийг * Хорооны сайтад байршуулахыг зөвшөөрсөн эсэх
						Тийм /Үгүй	Сургалтын гэрчилгээний дугаар	Хамрагдсан он сар өдөр	
1.									
2.									
3.									

\*Брокер агентын овог, нэр, утасны дугаар, гэрчилгээний дугаар

Анхааруулга: Дээрх хүснэгтийг бүрэн гүйцэд, үнэн зөв мэд

